

24



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 25

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга,
Засаг даргаар ажиллаж байсан үе үеийн дарга нарт
хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол түмний уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргаар ажиллаж байсан үе үеийн дарга нарт жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 15-ны дотор хүндэтгэл үзүүлж байхаар тогтсугай.

2. Хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Норов/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЭНХБАТ



0121038